



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалт болон тус компанийн 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/117 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрхийг нь хязгаарласан “Хүннү эмпайр ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг “Хүннү эмпайр ҮЦК” ХХК /Т.Азжая/-д анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1522630279

ХҮННҮ-ЭМПАЙР ҮЦК ХХК

МХБ-Д

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Самбуугийн гудамж. 16/4, Хот айл буйлдинг оффис, 34 тоот
Утас: 7777-8881, Е-майл: hun.frc.mgl@gmail.com, web site: hun.mn

2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

№46/2022

Албан хүсэлт

2022 оны гишүүнчлэлийн хураамж болон терминалын төлбөрүүдээ төлж барагдуулсан тул арилжаанд оролцох эрхийг нээж өгнө үү.

Холбогдох утас: 99093069, 77778881

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Т.АЗЗАЯА